



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn)  
Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

2023.03.29 № 01/252  
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН БАЯН-ӨНЖҮҮЛ  
СУМЫН ХҮН ЭМНЭЛГИЙН ДАРГА  
Я.НАРАНСАЙХАН ТАНАА

### Г Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийхээр төлөвлөсөн.

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөхөөс татгалзаж байна. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланда дүгнэлт өгөхөд хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй байна.

#### Дүгнэлт өгөхөөс татгалзсан үндэслэл

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Хүн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнийг үнэн зөв илэрхийлэгдсэнийг нотлох баримт байхгүй, хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй зэрэг нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтуутай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг”, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Хэмжилт”, “Тасалбар болголт” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Санхүүгийн тайланда төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланда дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

